

2025 он 03 сар 14 өдөр

Дугаар 057/04

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Нэгж эрх эзэмшигчдийн хурал
зарлан хуралдуулах тухай*


Монгол Улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны №64 тоот тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн зохицуулалтыг тус тус үндэслэн “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

“Үндэсний Хувьчлалын Сан” ХОС-ийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг **2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал тауэр, 17 давхар, Криптос ресторан** хаягт хуралдуулсугай.

1. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, Нэгж эрх эзэмшигчдийн хурлын дэгийг Хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг Гуравдугаар хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг Дөрөвдүгээр хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт материалын жагсаалтыг Тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хуралд оролцох эрхтэй Нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдрөөр тогтоосугай.
3. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн дотор хүргүүлсүгэй.
4. Хурал хуралдуулах тухай мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Ард Менежмент ҮЦК ХХК-ийн албан ёсны цахим хаяг <https://ardmanagement.mn/> дамжуулан 2025 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн дотор нийтэд зарласугай. Давган зарыг 2025 оны 4 дугаар сарын 3-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулсугай.
5. Нэгж эрх эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, танилцуулга зэрэг бусад холбоотой баримт бичгийг бэлэн болгож 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
6. Нэгж эрх эзэмшигчдийн хуралд оролцох боломжгүй нэгж эрх эзэмшигчдийн Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2025 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 16:00 цагаар тасалбар болгосугай.

7. Нэгж эрх эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг Ард Applikeйшн болон цаасан хэлбэрээр хослуулан авсугай.
8. Хурлын даргаар “Үндэсний Хувьчлалын Сан” ХОС-ийн ТУЗ-ийн дарга Б.Золбоог томилсугай.
9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
 - Хурал зохион байгуулах комиссын дарга:
“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Даваасамбуу;
 - Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн Сангийн менежер У.Сүхларь;
“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн Сангийн менежер, Т.Батбаяр;
10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
 - Тооллогын комиссын дарга:
Ө. Бямбагэрэл, Хуулийн зөвлөх, Ард Секюритиз ҮЦК ХХК;
 - Тооллогын комиссын гишүүд:
Ч.Даваацэрэн, Санхүүгийн шинжээч, Ард Секюритиз ҮЦК ХХК;
А.Эрхбилгүүн, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Ард Секюритиз ҮЦК ХХК;
11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Даваасамбууд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ЗОЛБОО